

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Норовын Лувсанцэрэн	Дугаар	L088
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Баянмөнх
Төрсөн газар	Баянмөнх сум	Төрсөн он	1914
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зоригтын хошууны хийд, Доржсэмбийн хурал, Баянмөнхийн хийд	Сүм хийдийн дугаар	ХЭБМ 044, ХЭБМ 043,ХЭБМ 042
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Баянмөнх сумын Зоригтын хошууны хийд

-Хуучин сүм хийдүүдийн талаар судалгаа хийж явнаа. Баянмөнх сумд 5 сүм хийд байжээ. Баянмөнхийн хийд, Гол дайчин чойр, Зоригт бэйсийн хошууны хийд-Дашбалбарын хийд, Билэгт ахайн хийд, Манбын хурал гэсэн ийм таван хийд тэмдэглэгдсэн байна.

Гол дайчин чойр гэдэг хийд нь Хунд нуур гэдэг газар байсан байна. Энэ хийдийн түүрх одоо хаана байгаа юм бол?

Одоо хаана байсан юм бол доо? Цагаан эргийн тэнд нэг хийд байсан юм.

Баянмөнхийн хийд чинь гол хийд нь. Сэмбийн хошуун дээр нэг байсан юм. Тэрнээс баруунтшаа гол хийд нь Зоригтын дацан гэдэг чинь тэнд Эргэцэг дээр байсан юм.

-Та өөрөө хаана шавилан сууж байсан юм бэ?

Гол хийд дээр. Чойртой, Ламринтай, Хошуу ганжууртай, 5 дацан байсан юмуу даа. (4 ч юмуу)

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Таван дацан байсан юм уу?

Ламрин, Ганжуур, Чойр гээд 4 ч юм уу.

-Цогчэн?

Цогчэн ч яахав байсан юм.

-Гол дацан нь Баянмөнхийн дацан нь хаана байсан юм?

Эргэцэгт байсан юм.

-Та хэдэн настайдаа шавилан сууж байсан бэ?

Арван хэд гарантай хориод настай л байсан байх даа.

-Тэгээд хэдэн онд байгуулагдаад хэдэн онд баларсан юм бол?

Чойр нь сүүлд байгуулагдсан юм. Луу жил байгуулагдсан юм гэнэ лээ. Хамгийн сүүлд Чойр нь байгуулагдсан гэдэг. 100 гаран жилийн цаана л байгаа байх даа.

-Ер нь Баянмөнхийн дацан хэдэн онд ямар хүний санаачилгаар байгуулагдсан юм бол?

Хошууны ноён нь л байгуулсан байх. Яг тэр гэж мэдэх юм алга.

-Хэдэн онд хаагдсан бэ?

Гучин хэдэн онд л хаагдсан юм даа.

-Хаагдах үеийн хийдийн гэсгүй унзад нар нь хэн байсан юм бол?

Хурлаа хаахаас нь өмнө нь баригдаад явцгаасан. Тэгээд хоосон хөндий баахан байсан. Тэгээд юмыг нь буулгаад ийш тийш нь болгосон. Нэг өвөл өнжөөд буулгасан.

-Лам нарыг баригдсаны дараа хийдийг буулгасан уу?

Дараа жил нь тэгээд хавраас нь эхэлж буулгасан.

-Баянмөнхийн дацан хэр олон ламтай байсан бэ?

Олон байсан байх. Чухам хэд байсныг мэдэхгүй. Дээр үед 1000 ламтай байсан гэж ярьдаг байсан. Тэр нэлээн дээхнэ үеийнх байх. Сүүлдээ хэдэн зуун лам л байсан байх. Хамба нь Жамбал гэж байж байгаад баригдсан. Их унзад нь Жамц гэж хүн байсан. 4 том 4 бага унзадтай байсан. Тэрнээс дараачийн Дэндэв гэж байсан. 4 их унзадын нэг нь Шарав гэж байсан. Лувсандоо гэж байсан.

-Лувсандоо гэдэг нь сүүлд Мандалын хуралд очиж хурсан уу?

Дэлдэн Пунцагийн Лувсандоо гэдэг байсан. Цогчэн хуралд их унзад байсан. Тэнд очоогүй ээ.

-Бага унзад нар нь ?

Янз янзын л хүмүүс байсан. Солигдоод л байдаг байсан.

-Цорж, да лам нарыг нь санаж байна уу?

Да ламыг Наваан гэдэг хүн байсан.

Ширээт лам нь хэн гэдэг хүн байсан бэ?

Жамба гэдэг хүн байсан.

-Бусад дацангуудын цорж нар нь?

Чойрын шунлайв гэдэг нь Шиваан гэдэг хүн байсан. Лувсанцэрэн гэж нэг хүн байсан.

-Ламрин дацангийнх нь шунлайвыг та мэдэж байна уу?

Ламрин дацан гэж нэг жижигхэн дацан байсан. Самдан гэдэг хүн лам нь (шунлайв) байсан. Унзад нь одоо наад хурлын унзaduудаас очиж хурдаг байсан. Лам нар нь олон байгаагүй байх.

-Ганжуур дацангийнх нь лам нь ?

Дээрх хүмүүс л байсан.

-Гэсгүй нар нь ?

4 гэсгүйтэй байсан. Хамгийн сүүлд Бадрах гэдэг байсан.

-Өөр ямар онцлох хуралтай байсан бэ? Цам гардаг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гарахгүй ээ. Майдар эргэнэ. Хайлан хурдаг байсан. 3 хоног хурдаг Даншигийн хангал гэж байсан. Намар ч хурдаг өвөл ч хурдаг байсан. Цагаан сар битүүний үеийн хурлуудыг хурна. Цагаан сарын 15 хүртэл Ерөөлөө хурна. Хошууны хилийн дээсээр Ганжуур эргэдэг байсан. Эхлээд их холуур тойрдог л байсан. Сүүлдээ уулаа тойрдог болсон.

-Зоригт бэйсийн хошуунаас хамгийн том нь аль нь байсан юм бэ?

Энэ гол хийд нь л. Баянмөнхийн дацан гэж Баянмөнхийн энгэрт нэг дацан байсан. Өлзийт хошуунд нэг байсан. Ер нь 3 хийд л байсан даа. Миний мэдэх л энэ.

-Өөр Баянмөнхийн хийдийн талаар, жасын талаар?

Айл айлд л байсан байх. Адуу, үхрээрээ байсан.

-Лам нарыг барихаас өмнө жасыг нь хураасан байх ?

Тийм.

-Чойроо ямар игчаагаар голлодог байсан бол?

Гүнчин ламын игчаагаар.

Гавж гэвшийн дом тавьдаг байсан уу?

Байсан.

-Зохиол бүтээл бичиж байсан лам нар байсан уу? Хутагт хувилгаан тодорч байсан уу?

Бичиж байгаагүй байхаа. Би хутагт хувилгаан гэж сонсоогүй. Цорж лам гэж нэг хүн байсан юм гэнэ лээ. Намайг жаахан байхад. Уул хангайхнаа тахилгын судрыг бичдэг хүн байсан л байх л даа.

-Зоригт бэйсийн хошуунд Жод хурдаг хийд байсан уу?

Өлзийт хошуунд л нэг тийм холимог юм байсан юм.

-Баянмөнхийн жижиг хийдтэй байсан гэсэн тэнд юу хурдаг байсан юм бол?

Манба хурна. Шарын шашны хийд байсан. Баянмөнх уулынхаа энгэрт байсан .

-Дацан суурингийн суурь маань яг хаана байгаа вэ?

Хөндийн баруунтай. Саравч байснаас баруун тийшээ. Дацан худаг гээд байдаг тэр чинь цаана нь л байдаг байсан.

-Та хэдтэйдээ шавилан сууж байсан бэ?

Арван хэдтэй байсан. Тэгээд 22-той больсон.

-Мамбын хурлын талаар ярьж өгөөч?

Тэр яахав Мамбын дацан гэж байсан. Би сууж байгаагүй.

-Өлзийтийн хошуун дээр ямар хурал байсан юм бол?

Жодын хурал байсан. Доржсэмбийн хурал гэж байсан.

- Доржсэмбийн хурал гэж тэмдэглэгдсэн байгаа.

Тэр чинь Өлзийт хошууны хурал мөн.

-Доржсэмбийн хурал нь Дашбалбарын өргөө Тооно уул гэдэг газар байх уу?

Өлзийт хошуу гэсэн л нэртэй газар.

-Хунт нуурын хурал гэж та сонссон уу?

Энд хийд байсан юм байх даа. Би л лав сонсоогүй. Тэр Элэгний хурал гэдэг чинь хавар намартаа эвийн хурал нэг хурчихаад тардаг тийм байсан. Элэгний хурал гэж Дархан сумандаа орно. 3 овоо гэдэг чинь Энгэрийн шанданы хийд. Энгэрийн Шандны хийдийг чинь Жаалуу Шаравын хийд гэдэг байсан. Жаалуу Шаравын гаргасан хийд. Жодын хуралтай, цамтай байсан. Миний мэдэх энэ хавьд өөр цамтай газар байгаагүй.

-Таны сууж байсан дацангийн төвд нэрийг нь юу гэдэг байсан юм бэ?

Ганжуур дацанг Лэгшидлин гэдэг байсан. Гол дацанг Түвдэннамбаржалбаалин гэдэг байсан. Ламрим ч яахав ламрим нэртэйгээ. Чойрынх нь Дашчойлон гэдэг байсан.

-Энгийн хүмүүс сүсэгтнүүд дацангуудаа юу гэж нэрлэдэг байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

- Миний сууж байсныг хүмүүс Ганжуур дуган гэдэг байсан.
- Та аль дацанд нь голчлон суудаг байсан бэ?
- Бүгдэнд нь л. Баруун дацан гол дацанд нь хурж байсан.
- Та Чойрт хурж байсан уу?
- Хурж байсан.
- Та ямар зиндаанд хүрсэн байсан бэ?
- Ум сарвууд явж байсан.
- Та хаана дом тавьсан бэ?
- Дацан дээрээ.
- Таны зиндаанд хэдэн хүн байсан бэ?
- 30-аад хүн байсан.
- Таны дээр хэдэн зиндаа байсан бэ?
- Ум нямба, зод гаарамба, гавж гээд 4 байсан юмуу даа.
- Таны игчааны багш чинь ямар хүн байсан юм бэ?
- Тэр дээр нас барсан. Жамц гэдэг хүн байсан.
- Төвд лам нар залдаг байсан уу?
- Үгүй байх аа. Төвд лам нар ирж байгаагүй байх аа. Мэдэхгүй юм.
- Хүрэнээс лам ирж байв уу?
- Эрхбиш ирж байсан улс байсан л байх. Чухам тэгээд багшилж байсан юм уу, Мэдэхгүй ээ.
- Ямар хийдтэй харилцаа холбоотой ойр байв?
- Хамрын хийд, Бэрээвэнгийн хийдтэй л ойр байсан даа.
- Та 1990 оноос шашин сэргэснээс хойш хурал хурсан уу?
- Үгүй.
- Таны хурж байх үеийн таны болон дээд доод зиндаанаас үлдсэн хүн бий юу?
- Нэг хүүхэд байсан. Ганц нэг надаас дүү хүн бий. Лувсан гээд. Одоо Хэрлэнбаян-Улаанд бий.
- Та хаагдсанаас хойш ямар юм хийсэн бэ?
- Янз янзын л юм хийдэг байсан.
- Таны үед аль аль овоог тахьдаг байсан бэ?
- Уулнуудыг л тахьдаг байсан.
- Ямар шүтээнтэй байсан юм болоо?
- Дамдин дорлиг. Ядам нь юу билээ дээ.
- Зуугийн шүтээн гэдэг ч юм уу, тийм шүтээн байсан уу?
- Шүтээнийг нь мэдэхгүй. Цогчэн гэдэг нь Чойжоо сахиустай, Ламрим гэдэг нь Жамсран сахиустай, Чойр гэдэг нь Гомбо сахиустай байсан.
- Хийдээ тойрсон суварга байсан уу?
- Ганц цагаан суваргатай байсан.
- Лам нар нь хаанаа байрладаг байсан бэ?
- Баруун хүрээ, зүүн хүрээндээ байдаг байсан.
- Ном барладаг байсан уу?
- Үгүй ээ. Би тийм юм сонсоогүй.
- Та гол хурлуудынх нь талаар ярьж өгөөч?
- Мэдэхгүй. Чойрт нэг гавжийн дамжаа барих гэж байсан. Майдараа зуны эхэн сард хурдаг байсан. Жилдээ нэг л эргэнэ. Ганжуураа бас нэг л эргэнэ. Тоотой лам нар л эргэдэг байсан.
- Бурхан багшийн дүйчин өдөр ямар хурал хурдаг байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хурдагуудыгаа л хурдаг байсан байх.

-Нүгнээ хурдаг байсан уу?

Тийм. Ганжуураа 10 хоног хураад дунд нь нүгнээтэй. Маанийн бүтээл хийдэг байсан. Баруун хойно нь дандаа нүгнээтэй.

-Дацангуудын барилгын талаар?

Модон дугангууд л байсан. Барагтай байсан. Нэг их том байгаагүй ээ.

-Яг хэдэн дуган байсан бэ?

5 байсан юм шиг байна.

-Маарамба, аграмбын дом тавьдаг байсан уу?

Үгүй.

-Гэвш дом тавихад хэдэн жил сурч байсан бэ?

Мэдэхгүй юмаа.

-Гаарамбын дом хэдэн жил явах вэ?

Янз янз л байдаг байсан. Номоороо болдог байсан юм уу, юмаараа болдог байсан юм уу мэдэхгүй.

-Таны зиндаанаас дээд зиндаанд орсон хүн байсан уу?

Байхгүй ээ.

-Таныг гэвш дом тавихад хэдэн лам байсан бэ?

30-аад л лам байсан байх.

Хэрлэнгийн үрд нэг жаахан хурал байсан. Намар хурдаг. Эвийн хурал гэдэг нь ганц хоёр хонь өгөөд хурдаг хурал байсан. Одоо тэр Зараа булангийн тэр чинь нэлээн дорвитой газар байсан. Дандаа эвийн хуралтай. Олон хуралтай газар байсан.

-Урд Мандалын суурин гэдэг чинь Гачин дацан гэж байсан юм уу?

Мандалын сууринд чинь Билэгт ахайн дацан байсан. Гачин дацан гэдэг чинь тэр.

-Өөр энэ хавьд хурлын газар, дацангууд байсан уу?

Байгаагүй ээ. Эвийн хурал гэдэг чинь намар 3 юмуу 5 хоног хурал хураад тардаг байсан.

-Билэгт ахайн дацан хэр том дацан байсан бэ?

Жаахан байсан.

-Хийдийн юмнуудаас үлдсэн юм айлуудад байгаа болов уу?

Байхгүй байхаа. Шатаагаад дуусгасан байсан.